



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/93/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой номлолт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор С.Бат-Эрдэнэ
Утас: 260512 Цахим хаяг: bateredenes@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Баян суварга аудит" ХХК-ийн
захирал С.Догожинсүрэн
Утас: 99126723 Цахим хаяг: doljinsuren9@yahoo.com

АГУУЛГА

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлангалын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	12
4.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл.....	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
8. Аудитын илрүүлэлт.....	16
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ДЭХ	Дулааны эрчим хүч
ЗГХЗГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
СТОУС	Санхүүгийн Тайлангальн Олон Улсын Стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХХ	Төрийн өмчийн хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын өгөг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЧТА	Хөдөлмөрийн чадвар түр алдалт
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХЯ	Эрчим хүчний яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Баян голуу 3, Засгийн Газрын 17 байр
Утас 31-04-31, Факс 31-26-42-93
E-mail: info@audia.gov.mn

ДУЛААНЫ ХОЕРДУГААР ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨХХ-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ц.МИНЖИНХҮҮ ТАНАА

02022.03.15 № 07/524

тасгай _____ -нм № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХХ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХХ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохиистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХХ-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд тайлант оны нийт орлогыг 24,714.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 27,710.9 сая төгрөгөөр, алдагдлыг 2,996.2 сая төгрөг байхаар тодотгон баталсан байна. Гүйцэтгэлээр 25,980.5 сая төгрөгийн орлого бүрдүүлтг орлогын төлөвлөгөөг 5.1 хувиар давуулан биелүүлж, 26,247.9 сая төгрөгийн зардал гарган, 267.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХХ нь 2021 онд 4 зорилтот бүлгийн хүрээнд 178 арга хэмжээ төлөвлөснөөс 90.4 хувийн биелалттай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ өнгөд эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	188,204,412.98	567,632,156.43
1.1.2	Дансны авлага	2,187,149,390.79	3,254,122,002.38
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	45,000.00	1,760,507.70
1.1.4	Бусад авлага	2,885,084.83	32,958,673.04
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Баруу материал	1,141,487,753.67	1,390,567,911.36
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	69,772,794.94	633,682,082.88
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,589,544,437.21	6,850,723,333.77
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	28,910,568,693.33	27,488,478,258.57
1.2.2	Билет бус хөрөнгө	19,495,180,947.60	19,487,941,304.82
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	48,405,749,640.93	46,976,419,563.39
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	51,995,294,078.14	52,827,142,897.16
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,322,770,803.62	2,248,961,417.66
2.1.1.2	Цалингийн өглөг	-	1,051,275.09
2.1.1.3	Татварын өр	170,446,709.06	383,001,082.72
2.1.1.4	НДШ-ийн өглөг	449,340.00	-
2.1.1.5	Богино хугацаат эзэл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,214,928.00	3,064,032.12
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	192,181.91	110,700.91
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,495,073,962.59	2,636,188,508.60
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат эзэл	481,273,847.93	439,390,783.87
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	481,273,847.93	439,390,783.87
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,976,347,810.52	3,075,579,292.37
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч-гөрийн	11,797,535,542.78	11,797,535,542.78

Дулааны хөврдугаар цэцэглэсэн станц ТӨХХ-ийн 2021 оны өмнөхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,775,972,666.78	14,775,972,666.78
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн мөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	24,257,881,346.72	24,257,881,346.72
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(812,443,288.66)	(1,079,825,951.49)
	Тайлангийн үеийн ашиг	-	(267,382,662.83)
	Өмнөх үеийн ашиг	(812,443,288.66)	(812,443,288.66)
2.3.11	Эздийн өмчийн дүн	50,018,946,267.62	49,761,663,604.79
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	51,995,294,078.14	52,827,142,897.16

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	24,271,977,614.04	26,766,623,434.36
2	Борлуулалтын өртөг	22,631,193,497.08	23,789,211,459.10
3	Нийт ашиг (алдагдал)	1,640,784,016.96	1,977,411,975.26
4	Түрээсийн орлого	23,009,527.24	15,119,999.99
5	Хүүгийн орлого	27,149,814.21	1,587,502.31
6	Ногдол ашигийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨХТ/	-	-
8	Бусад орлого	122,994,240.52	197,144,765.54
9	Борлуулалт, маркетингийн зардал	18,781,540.00	8,384,200.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,516,105,905.63	2,219,591,259.55
11	Санхүүгийн зардал	12,453,191.96	11,615,530.68
12	Бусад зардал	160,536,273.46	218,904,637.96
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	2,568.34	(26.87)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(19,858,531.31)	-
15	Билт бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(913,795,275.09)	(267,231,411.96)
19	Орлогын татварын зардал	2,714,981.41	151,250.87
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(916,510,266.50)	(267,382,662.83)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(916,510,266.50)	(267,382,662.83)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	11,797,535,542.78	10,176,880,577.59	24,495,500,366.92	(144,264,763.93)	46,325,651,723.36
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				248,331,731.77	248,331,731.77
Залруулсан үлдэгдэл	11,797,535,542.78	10,176,880,577.59	24,495,500,366.92	104,066,967.84	46,573,983,455.13
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(916,510,256.50)	(916,510,256.50)
Өмчид гарсан өөрчлөлт			(237,619,020.20)		(237,619,020.20)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		4,599,092,089.19			4,599,092,089.19
2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	11,797,535,542.78	14,775,972,666.78	24,257,881,346.72	(812,443,288.66)	50,018,946,267.62
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	11,797,535,542.78	14,775,972,666.78	24,257,881,346.72	(812,443,288.66)	50,018,946,267.62
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(267,382,662.83)	(267,382,662.83)
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	11,797,535,542.78	14,775,972,666.78	24,257,881,346.72	(1,079,825,951.49)	49,751,563,604.79

/төгрөгөөр/

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	24,052,747,737.46	24,579,013,051.10
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	23,805,996,990.76	24,282,387,288.84
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	83,825,444.00	104,816,621.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	162,925,302.70	191,809,141.26
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	22,234,857,076.64	22,358,854,872.95
1.2.1	Ажиллагчдад төлсөн	7,583,836,396.91	7,138,447,148.29
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,852,128,993.39	2,254,456,473.60
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	8,355,861,956.10	8,678,533,996.11
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	672,831,930.21	579,627,844.56
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,757,959,646.00	1,916,183,343.15
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,823,667,816.30	1,563,803,316.20
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	9,536,561.43	13,106,540.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	179,033,776.30	214,696,211.04

/төгрөгөөр/

Дулааны хоёрдугаар цацлалын станц ТӨХЖ-ийн 2021 оны саяхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

1.3	Түгдсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,817,890,660.82	2,220,158,178.15
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	27,149,814.21	1,587,502.31
2.1.1	Түгдсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгавны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан үнэмлэхүй орлого	27,149,814.21	1,587,502.31
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,024,475,006.15	1,842,317,910.14
2.2.1	Түгдсэн хөрөнгө олж эзэмшэхэд төлсөн	2,024,475,006.15	1,842,317,910.14
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшэхэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшэхэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшэхэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,997,325,191.94)	(1,840,730,407.83)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,410.81	92.25
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гарснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гарснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хэвцэг	-	-
3.1.4	Бусад	4,410.81	92.25
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,842.47	119.12
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн гурзасгийн өслөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад	1,842.47	119.12
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,568.34	(26.87)
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(179,431,962.76)	379,427,743.45
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эзний үлдэгдэл	367,656,375.76	188,204,412.98
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эзсийн үлдэгдэл	188,204,412.98	567,632,156.43

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Түүжлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь	
			Төлөөлөгч	Гүйцэтгэл			
1	Тайлбар						
Боловсруулах	ЦЭХ	сая кВт.ц	155.2	156.6	153.8	2.8	98.2
	ДЭХ	млн.Гкал		239.0	234.9	4.1	98.3
	хувилар	%	19.0	12.4	12.0	0.4	98.8
	биетээр	сая кВт.ц	12.3	19.4	18.5	0.9	95.4
	Түгээл	ЦЭХ	сая кВт.ц	136.2	137.2	135.3	1.9
	ДЭХ	млн.Гкал	234.2	239.0	234.9	4.1	98.3
2	Үйлт орлого	сая.төг	24,645.1	24,714.7	25,680.5	(1,205.8)	105.1
	Түүхээс -борлуулалтын орлого	сая.төг	24,272.0	24,566.7	25,766.6	(1,199.9)	104.9

**Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан**

	-Үйл ажиллагааны бус орлого	сая.төг		148.0	213.9	(65.9)	144.5	
3	Нийт зардал	сая.төг	25,361.6	27,710.9	26,247.9	1,463.0	94.7	
	Үүнээс: -Үйл ажиллагааны зардал	сая.төг		27,460.1	26,029.0	1,431.1	94.8	
	-Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	328.1	250.8	218.9	31.9	87.3	
4	Татварын өмнөх ашиг/алдагдал	сая.төг		(2,996.2)	(267.4)	(2,728.8)	8.9	
5	Татварын дараах ашиг/алдагдал	сая.төг	(916.5)	(2,996.2)	(267.4)	(2,728.8)	8.9	
6	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	төгрөг	1.0	1.1	1.0	0.1	90.9	
7	Нийт авлага	сая.төг	2,190.0	2,150.0	3,922.5	(1,772.5)	182.4	
	Үүнээс: -Эрчим хүчний	сая.төг		2,120.0	2,929.8	(809.8)	138.2	
	-Бусад	сая.төг		30.0	992.7	(962.7)	3309.0	
8	Нийт өглөг	сая.төг	1,976.4	2,439.4	3,075.6	(636.2)	126.1	
	Үүнээс: -Урт хугацаат	сая.төг	1,495.1	439.4	439.4	-	100.0	
	-Богино хугацаат	сая.төг		2,000.0	2,636.2	(636.2)	131.8	
9	Нийт ажилчдын тоо	тоо		313	303	(10)	96.8	
10	Нийт цалингийн сан	сая.төг		8,148.4	7,861.2	287.2	96.5	
1	Жишмэл түлшний зарцуулалт	ЦЭХ	гр/кВт.ц	578.0	608.9	599.1	9.8	98.4
1		ДЭХ	кг/Гкал	190.3	197.5	195.8	1.7	99.1
1	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт	сая.төг	2,093.1	2,840.8	2,502.3	338.5	88.1	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад мөнгөн хөрөнгө, бараа материалын бүртгэл, авлага, өглөгийн журналын бичилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-аас 2022 оны 3 дугаар сарын 06-ны хооронд Баян суварга Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Юра, аудитор Х.Тунгалагтуяа, аудиторын туслах Ч.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Мөнхзул, захирал С.Должинсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Б-01/32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрdej байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус компанийн 2020 он, 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас хяналт шалгалт хийсэн боловч одоогоор дүгнэлт гараагүй байна.

ЭХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Эрчим хүчний салбарын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж, тус компанийн шилэн дансны хөтлөлтийг 96.6 хувь буюу хангалттай гэж дүгнэжээ.

Мөн компанийн Хяналт, техник аюулгүй ажиллагааны хэлтсийн 2021 оны ажлын төлөвлөгөөгөөр нийт 58 ажил, үүнээс дотоод аудиторын гүйцэтгэх 10 ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. 2021 оны төлөвлөгөөт шалгалт болон Гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн дагуу нийт 10 асуудлыг дотоод аудитаар шалгаж, 18 зөвлөмж өгч, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг акрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 24,445.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 244.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн зорилго нь Улаанбаатар хотын цахилгаан, дулааны эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдлыг хангах зорилгоор суурилагдсан хүчин чадлаа бүрэн ашиглах, үндсэн тоноглолын эвдрэл саатлаас шалтгаалсан зогсолт гаргахгүй байхад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг "Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах, үйлдвэрлэл эрхэлж, ажил үйлчилгээ үзүүлнэ" гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨХК гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс ТӨБЗГ 30.0 хувь, Эрчим хүчний яам 70.0 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийг БНМАУ, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан гэрээний дагуу 1960-1962 онд барьж байгуулан ашиглалтад оруулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;..." гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг ТУЗ-ийн тогтоолоор болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор тус тус томилж байгаа нь ТБОНӨТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.6-д "төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих" гэж заасантай нийцэж байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөлөл /ЭХЯ, ЗГХЭГ, ТӨБЗГ/-ийг хэрэгжүүлэгч 6, хараат бус 3, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. ТУЗ-ийн хурлыг 2021 онд 9 удаа зохион байгуулж, 31 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. 2021 онд компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 01, 02 дугаар тогтоолоор ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг бүрэн шинэчлэн баталжээ.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 9 гишүүдийн цалин, урамшууллыг 65.6 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д

"...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10-т "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно." гэж заажээ.

Тайлант онд ТУЗ-ийн үйл ажиллагаа, засаглалтай холбоотой журамд дараах шинэчлэлт, өөрчлөлт орсон байна. Үүнд:

ДЦС-2 ТӨХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 14 дүгээр тогтоолоор "ТУЗ-ийн ажиллах журам", "Нэр дэвшүүлэх хорооны журам", "Цалин урамшууллын хорооны журам", "Аудитын хорооны ажиллах журам"-ыг тус тус шинэчлэн баталжээ.

2021 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 78.2 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 76.6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 75.2 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 0.1 сая төгрөг, шатахууны зардалд 0.7 сая төгрөг, бусад зардалд 0.6 сая төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 10 нэгжээр бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна.

Тайлант онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийг "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-оор шагнажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль /2021.07.02/;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай";
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай";
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам";
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 479 дүгээр тогтоол "Цахилгаан, дулааны тарифт өөрчлөлт оруулах тухай".

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	188.2	567.6	379.4
Авлага	2,187.1	3,254.1	1,067.0
Урьдчилгаа (урьдчилж гарсан зардал)	69.8	633.7	563.9
Бараа материал	1,141.5	1,360.6	219.1
Үндсэн хөрөнгө	28,910.6	27,488.5	(1,422.1)
Биет бус хөрөнгө	19,495.2	19,487.9	(7.3)
Нийт хөрөнгийн дүн	51,995.3	52,827.1	831.8
Өр төлбөрийн дүн	1,976.4	3,075.6	1,099.2
Богино хугацаат өглөг	1,495.1	2,636.2	1,141.1
Урт хугацаат өглөг	481.3	439.4	(41.9)
Эздийн өмч	50,018.9	49,751.6	(267.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	51,995.3	52,827.1	831.8

Касс дахь бэлэн мөнгө 4.0 сая төгрөг, арилжааны банкны 7 харилцах дансанд 563.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэл 3,254.1 сая төгрөг болж 1,067.0 сая төгрөгөөр өссөн нь нэр бүхий 46 байгууллагаас авах хэрэглэгчдэд борлуулсан цахилгаан эрчим хүч, уур, ус, дулааны эрчим хүчний борлуулалтын авлагыг барагдуулаагүйгээс шалтгаалжээ. Дээрх авлага нь тайлант оны эцэст үүссэн ба хугацаа хэтэрсэн, он удаан жилийн насжилттай авлага байхгүй бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Тайлант оны эцэст Диспетчерийн үндэсний төв ХХК-аас авах цахилгаан эрчим хүчний авлага 2,813.0 сая төгрөг болж 1,051.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Тайлант онд гэрээ сунгагдсан их засвар, техник зохион байгуулалт, арга хэмжээний ажлын төлбөрт 552.8 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,360.6 сая төгрөг болж 219.1 сая төгрөгөөр өссөн нь өмнөх оноос нүүрсний үлдэгдэл 356.9 сая төгрөгөөр, химийн материал 6.0 сая төгрөгөөр, аваарын нөөц 34.3 сая төгрөгөөр, тос тосолгооны материал 5.7 сая төгрөгөөр өсөж, үндсэн сэлбэг хэрэгсэл, хангамжийн материалын үлдэгдэл 183.8 сая төгрөгөөр буурсан нь шалтгаалжээ.

Тайлант онд 12,435.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 12,189.0 сая төгрөгийн хөрөнгийг үйлдвэрлэлд зарцуулж, 61.8 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд шилжүүлж, 0.1 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд 368.2 сая төгрөгийн технологийн шинэчлэлийн шаардлагад нийцэхгүй, марк хэмжээ тохирохгүйгээс ашиглагдахгүй түүхий эд материал байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 2,038.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан дуусаагүй барилга, байгууламж 576.2 сая төгрөг, тоног төхөөрөмж угсарч суурилуулсан 122.9 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын шийдвэрээр балансаас баланст шилжүүлсэн 14.0 сая төгрөг, акталсан 42.2 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр хасагдсан байна.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны 185 дугаар тогтоолоор нийт 42.2 сая төгрөгийн өртөгтэй 11 ширхэг хөрөнгийг акталж, 632.3 сая төгрөгийн хөрөнгийг ангилал хооронд залруулсан байна.

Биет бус хөрөнгийн 12.3 сая төгрөгийн бууралтад программ хангамжийн тайлант оны тооцсон хорогдол шалтгаалжээ.

Дуусаагүй барилга данс 599.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь 2021 онд эхлүүлсэн хурлын заал, цайны газрын дуусаагүй барилгыг бүртгэсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 2,636.2 сая төгрөг болж 1,134.8 сая төгрөгөөр өссөн нь дансны өглөг 921.0 сая төгрөгөөр, дулааны эрчим хүч, уурын төлбөрийн урьдчилж орсон орлого 1.8 сая төгрөгөөр, бусад татварын өглөг 212.0 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Урт хугацаат өр төлбөр дансанд УБДС ТӨХК-тай 2012 оны 2012/87 дугаар бүхий дамжуулан зээлдүүлэх гэрээгээр үүссэн 439.4 сая төгрөгийн өр байна. Урт хугацаат өрийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу гүйцэтгэж байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйлдвэрлэл, үйлчилгээний өртөг буюу борлуулсан бүтээгдэхүүний өртөг зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг шууд материал, шууд хөдөлмөрийн зардал, шууд хуваарилагдах тогтмол, хувьсах үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал, шууд бусаар хуваарилагдах зардлыг хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Өмнөх онтой харьцуулахад нийт зардал 908.6 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүнд борлуулалтын өртөг 1,158.0 сая төгрөгөөр, бусад зардал 58.4 сая төгрөгөөр нэмэгдэж, ерөнхий удирдлагын зардал 296.5 сая төгрөг, борлуулалт маркетингийн зардал 10.4 сая төгрөг, санхүүгийн зардал 0.9 сая төгрөгөөр тус тус буурсан нь шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт үйлдвэрлэлийн цех, тасгуудын зардлуудыг хамруулсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/157 дугаар тушаалаар Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон баталж, тайлант оны нийт орлогыг 24,714.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 27,710.9 сая төгрөгөөр буюу 2,996.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ-ний 66 арга хэмжээнд 2,840.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 25,980.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 26,247.9 сая төгрөгийн зардал гарган, 267.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 25,980.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,265.8 сая төгрөг буюу 5.1 хувиар давсан нь ЭХЗХ-ны 2021 оны 479 дүгээр тогтоолоор 2021 оны 4 дүгээр улиралд Диспетчерийн үндэсний төв ХХК-д худалдах цахилгааны чадлын тарифыг сард 1,204.6 сая төгрөг, УБДС ТӨХК-д худалдах дулааны тарифыг 2,377.00 төгрөг болгож нэмэгдүүлэн баталсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 26,247.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,463.0 сая төгрөг буюу 5.3 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь түлшний зардлыг 548.7 сая төгрөгөөр, үндсэн ба

нэмэгдэл цалин, НДШ-ийн зардлыг 296.0 сая төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын зардлыг 71.8 сая төгрөгөөр, гүйцэтгэх удирдлагын зардлыг 33.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 31.8 сая төгрөгөөр, түүхий эд материал, шатахуун зэрэг бусад ерөнхий удирдлагын зардлыг 481.5 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 66 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 2,502.3 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 267.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,728.8 сая төгрөгөөр буурсан нь нийт орлогыг төлөвлөснөөс 1,265.8 сая төгрөгөөр давуулан биелүүлж, нийт зардлыг 1,463.0 сая төгрөгөөр хэмнэсэн нь нөлөөлжээ.

Тайлант онд ногдол ашиг хуваарилаагүй бөгөөд түрээсийн төлбөрийн 40.0 хувь болох 0.4 сая төгрөгийн түрээсийн орлогыг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулан эсэхийг хамруулан шалгалаа.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК нь тайлант онд нийт 51,435.6 сая төгрөгийн 1368 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулж, хуулийн хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Өмнөх оны аудитаар дор дурдсан зөрчлийг таслан зогсоохоор албан шаардлага хүргүүлсэн боловч Эрчим хүчний салбарын Хамтын хэлэлцээрт өөрчлөлт оруулах боломжгүй, түүнд үндэслэн хийгдсэн үйлдвэрчний хороотой байгуулсан хамтын гэрээний заалтыг хэрэгжүүлж ажилласан гэж шалгагдагч байгууллагаас тайлбар ирүүлсэн бөгөөд 2021 онд зөрчил давтагдсан тул асуудлыг эрчим хүчний салбарын хэмжээнд авч үзэж Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланд тусгаж албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах нь зүйтэй байна. Үүнд:

- Байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан Хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3.13 дугаар заалтын дагуу Эрчим хүчний болон бусад салбарын "Тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнагдсан ажиллагсад болон ахмад ажилтнуудад сар бүр 10.0 мянган төгрөгөөр тооцон урамшуулал олгох;

- Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.4 дүгээр заалтын дагуу халаалтын улирлын хөнгөлөлтийг орон сууцанд амьдардаг ажилтнуудад жилд нэг удаа 100.0 мянган төгрөгөөр тооцон олгох.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Эрчим хүчний сайдын 2016 оны 97 дугаар тушаалаар баталсан "Эрчим хүчний салбарын шагнал олгох журам"-ын 5 дугаар зүйлийн 5.3, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 8 дугаар зүйлийн 8.3-д заасантай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 543.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 1.0 сая төгрөгийн алдааг залруулж, 492.6 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 49.6 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 42.7 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 95.5 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгснөөс албан шаардлагыг хэрэгжүүлэх боломжгүй талаар шалгагдагч байгууллагаас тайлбар ирүүлж, зөвлөмж 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1	42.7			1	42.7	
Зөвлөмж	6	95.5	6	95.5			
Нийт дүн		138.2		95.5		42.7	

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар "Титантауэр Констракшн" ХХК-тай байгуулсан цайны газар, хурлын заалны барилга барих ажлын гэрээний гүйцэтгэлийг шалгана.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт илрүүлсэн 203.4 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 203.4 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 244.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Зөрчилгүй" дүгнэлт өглөө.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн 3.5 сая төгрөгийн 12 зарлагын гүйлгээний цахим и-баримтыг хавсаргаагүй нь НӨАТ-ын тухай хуулийн 17.3.1-д "албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ;" 17.5-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр

тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Бараа, ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэх бүрд цахим и-баримтыг бүрдүүлэх, бэлтгэн нийлүүлэгчийн татварын и-баримт цахим хуудсанд баримт шивэлтийг хянах

2. Авлагын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Тайлант оны санхүүгийн тайлангийн урьдчилж төлсөн зардал дансанд НӨАТ-ын хойшлогдсон авлага нэрээр 80.9 сая төгрөгийг бүртгэж тайлагнасан нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Цахилгаан, дулаан, хий, усан хангамж, шуудан, харилцаа холбооны болон бусад тогтмол үйлчилгээнд албан татвар ногдуулах хугацааг төлбөрийн баримт үйлдсэн буюу төлбөрийг хүлээн авсан өдрийн аль түрүүнд хийгдсэнээр нь тогтооно” гэж заасантай нийцээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

НӨАТ-ын хойшлогдсон авлага нэрээр бүртгэж тайлагнасан 80.9 сая төгрөгийг 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулан авлагаар бүртгэх.

3. Журналын бичилттэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Бэлтгэн нийлүүлэгчдээс авах авлага, НӨАТ-ын авлага зэрэг дансдыг хасах үлдэгдэлтэй гарахаар стандарт бус гүйлгээ хийж “данс хооронд” гэсэн гүйлгээгээр тухайн дансдуудын үлдэгдлийг өглөг болгон залруулан давхардуулан бичилт хийсэн.

Эдгээр зөрчил нь Сангийн сайдын 100 дугаар тушаалын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2-т “Авлагын дэлгэрэнгүй дансны эхний болон эцсийн дебет үлдэгдлийн дүн нь ерөнхий дансны авлагын дансны эхний болон эцсийн үлдэгдэлтэй, харин эхний болон эцсийн кредит үлдэгдлийн дүн нь ерөнхий дансны урьдчилж орсон орлого дансны эхний болон эцсийн үлдэгдэлтэй тохирно” гэсэн заалттай нийцээгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллага бүрээр өглөг, авлага үүсгэх бичилтүүдийг зөв бүртгэж, санхүүгийн тайланг зөв илэрхийлэх

4. Бараа материалын данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Худалдаж авсан 68.3 сая төгрөгийн хангамжийн бараа материалыг зардалд шууд бүртгэж тайлагнасан нь Энэ нь тус компанийн НБББББ-ийн 5.1.3-т “бараа материалын дансанд 3 жилээс бага ашиглагдах хугацаатай хөрөнгийг БҮТЭЗ гэж хүлээн зөвшөөрч бараа материал дансны бүлэгт хангамжийн материал хэсэгт бүртгэнэ”, энэ хөрөнгийг шулуун шугамын аргаар хасагдуулж зардлаар хүлээн зөвшөөрнө гэж заасантай нийцэхгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

НБББББ-т заасны дагуу хөрөнгийг шулуун шугамын аргаар хасагдуулж, зардлаар хүлээн зөвшөөрч, өртөг зардлыг зөв тооцох.

5. Бараа материалын данстай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Бараа материалын анхан шатны баримтыг журналын бичилттэй тулган шалгахад нярвын тайлангаас журналын бичилт 1.7 сая төгрөгөөр илүү, 49.0 сая төгрөгөөр дутуу зөрүүтэй бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д

“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг үндэслэн, бараа материалын тайлан, журналыг үнэн зөв бүртгэж, тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянгаан төгрөгөөр/

А/А	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс				Зөвлөмж		
					Тоо	Дүн	Загруула	Акт	Албан шаардлага	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар													
1	Дулааны хойрдугаар цалиглаан станц ТӨХК	АХГ-2022/93/НА-СТА-ТӨА	Мөнгөн хөрөнгийн зарцуулалтын баримтад 12 гүйлгээний 3.5 сая төгрөгийн цахим баримтыг хавсаргаалгүй.	Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар багасган "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нохих заавар"-ын дагуу анхан шатны бүртгэл хөтөлж, мөнгөн хөрөнгийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих ханалтыг сайжруулах.	1	3,487.2						1	3,487.2
2	Дулааны хойрдугаар цалиглаан станц ТӨХК	АХГ-2022/93/НА-СТА-ТӨА	Тайлант оны санхүүгийн тайлангийн Урьдчилж төлсөн зардал/тооцоо дансанд НӨАТ-ын хойшлогдсон авлага нэрээр 80.9 сая төгрөгийг бүртгэж тайлагласан нь санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд буруу ойлголт өгөхөөр болсон байна.	НӨАТ-ын хойшлогдсон авлага нэрээр бүртгэж тайлагласан 80.9 сая төгрөгийг 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд зарцуулан бүртгэж.	1	80,895.6						1	80,895.6
3	Дулааны хойрдугаар цалиглаан станц ТӨХК	АХГ-2022/93/НА-СТА-ТӨА	Бэлтгэн нийлүүлэгчдээс авах авлага, НӨАТ-ын авлага, ХХОАТ-ын авлага, НДШ-ХЧТА тооцоо, Ажилчдаас авах авлага дансыг "данс хооронд" гэсэн гүйлгээгээр тухайн дансдууд болон өөрийн авлагын дансанд бичилт хийсэн.	Авлага, өглөгийн дансны бүртгэлийн бичилтийг байгууллагын НБ5555-т заасны дагуу үнэн зөв бүртгэж, цашид авлага, өглөгийн тайлан тооцоонд тавих дотоод ханалтыг сайжруулах.	1							1	

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	Түүнчлэн бүтээн нийлүүлэгчид өгөх өвлөг, Цалингийн өглөг, НБАТ-ын өглөг, ХХОАТ-ын өглөг, ҮХЭХАТ-ын өглөг, дансандуйг мөн дээрх байдлаар дансны харьцааг хийсэн байна.	Түүнчлэн бүтээн нийлүүлэгчид өгөх өвлөг, Цалингийн өглөг, НБАТ-ын өглөг, ХХОАТ-ын өглөг, ҮХЭХАТ-ын өглөг, дансандуйг мөн дээрх байдлаар дансны харьцааг хийсэн байна.	Түүнчлэн бүтээн нийлүүлэгчид өгөх өвлөг, Цалингийн өглөг, НБАТ-ын өглөг, ХХОАТ-ын өглөг, ҮХЭХАТ-ын өглөг, дансандуйг мөн дээрх байдлаар дансны харьцааг хийсэн байна.	Түүнчлэн бүтээн нийлүүлэгчид өгөх өвлөг, Цалингийн өглөг, НБАТ-ын өглөг, ХХОАТ-ын өглөг, ҮХЭХАТ-ын өглөг, дансандуйг мөн дээрх байдлаар дансны харьцааг хийсэн байна.	Түүнчлэн бүтээн нийлүүлэгчид өгөх өвлөг, Цалингийн өглөг, НБАТ-ын өглөг, ХХОАТ-ын өглөг, ҮХЭХАТ-ын өглөг, дансандуйг мөн дээрх байдлаар дансны харьцааг хийсэн байна.	Түүнчлэн бүтээн нийлүүлэгчид өгөх өвлөг, Цалингийн өглөг, НБАТ-ын өглөг, ХХОАТ-ын өглөг, ҮХЭХАТ-ын өглөг, дансандуйг мөн дээрх байдлаар дансны харьцааг хийсэн байна.	Түүнчлэн бүтээн нийлүүлэгчид өгөх өвлөг, Цалингийн өглөг, НБАТ-ын өглөг, ХХОАТ-ын өглөг, ҮХЭХАТ-ын өглөг, дансандуйг мөн дээрх байдлаар дансны харьцааг хийсэн байна.	Түүнчлэн бүтээн нийлүүлэгчид өгөх өвлөг, Цалингийн өглөг, НБАТ-ын өглөг, ХХОАТ-ын өглөг, ҮХЭХАТ-ын өглөг, дансандуйг мөн дээрх байдлаар дансны харьцааг хийсэн байна.	Түүнчлэн бүтээн нийлүүлэгчид өгөх өвлөг, Цалингийн өглөг, НБАТ-ын өглөг, ХХОАТ-ын өглөг, ҮХЭХАТ-ын өглөг, дансандуйг мөн дээрх байдлаар дансны харьцааг хийсэн байна.	Түүнчлэн бүтээн нийлүүлэгчид өгөх өвлөг, Цалингийн өглөг, НБАТ-ын өглөг, ХХОАТ-ын өглөг, ҮХЭХАТ-ын өглөг, дансандуйг мөн дээрх байдлаар дансны харьцааг хийсэн байна.	Түүнчлэн бүтээн нийлүүлэгчид өгөх өвлөг, Цалингийн өглөг, НБАТ-ын өглөг, ХХОАТ-ын өглөг, ҮХЭХАТ-ын өглөг, дансандуйг мөн дээрх байдлаар дансны харьцааг хийсэн байна.
4	Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/93/НА-СТА-ТӨА	2021 онд 68.3 сая төгрөгийн хангамжийн бараа материалыг шууд зардалаар бүртгэж тайлагнасан.	НБББББ-т заасны дагуу хөрөнгийг шулуун аргаар хасалдуулж зардалаар хүлээн зөвшөөрч, өргөг зардлыг зөв тооцох.	68,314.9	1	68,314.9				
5	Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/93/НА-СТА-ТӨА	Бараа материалын анхан шатны баримтыг журналын бүхэлтэй тулган шалгахад нэрвэйн гаргасан тайлангаас журналын бүхэлт 1.7 сая төгрөгөөр илүү, 49.0 сая төгрөгөөр дутуу зөрүүтэй бүртгэсэн байна.	Цаашд анхан шатны баримтыг үндэслэн, бараа материалын тайлан, журналыг үнэн зөв бүртгэж тайлагнах.	50,659.1	1	50,659.1				50,659.1
			Дүн		203,356.8	5	203,356.8				203,356.8
Санхүүгийн тайлангийн аудитгаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
			Дүн								
			Нийт дүн		203,356.8	5	203,356.8				203,356.8